



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08 дугаар сарын 17 өдөр Дугаар 75

Хэрлэн сум

LXXV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 77 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 17:00 цагт танхимаар 65,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Баар, караокед хийсэн хяналт шалгалтын нэгдсэн дүнг танилцуулж, холбогдох шийдвэр гаргах,

*Эрүүл мэндийн газар,  
Мэргэжлийн хяналтын газар*

2.Аймгийн Онцгой комиссын 2021 оны "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг тогтоох тухай" 89 дүгээр тогтоолыг хүчингүй болгох тогтоолын төслийг танилцуулах,

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс,  
Цагдаагийн газар*

3.Чойбалсан хот-Чулуунхороот сум чиглэлийн төмөр замын зорчигч тээврийн хөдөлгөөнийг явуулах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэх,

*УБТЗ-ын Баянтүмэн тасаг*

4.Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах,

*Мал эмнэлгийн газар*

5.Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалт болон 2021-2022 оны хичээлийн шинэ жилийн үйл ажиллагаатай холбогдуулан бэлтгэл ажлын явцыг танилцуулах,

*Боловсролын газар*

6.Хүнсний ногооны шинэ ургацын талаар танилцуулж, шийдвэр гаргуулах,

*Хүнс, Хөдөө аж ахуйн газар*

7.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичиг, хүсэлт танилцуулах,

*/ М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр*

- Улсын онцгой комиссын 2021 оны 06 дугаар албан даалгавар,
- Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн албан бичиг,
- “ДБЭХС” ТӨХК-иас ирүүлсэн албан хүсэлт,
- “Степ голд” ХХК-иас ирүүлсэн албан хүсэлт,
- Мөрөөдлийн ордон тоглоомын төвийн хүсэлтийг тус тус танилцуулна.

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа нарт:

1.1.Баар, караокены үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн удирдлагуудтай Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хамтарсан хариуцлагын гэрээ байгуулах, хууль тогтоомж, журам, хариуцлагын гэрээний биелэлт, цагийн хязгаарлалт болон халдвар хамгааллын дэглэмийг ханган ажилласан тохиолдолд үйл ажиллагааг эхлүүлэх,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,  
АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх нарт:

1.2.Баар, караокены үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 31 аж ахуй нэгжийн коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед ажиллаагүй хугацааг тооцож, тусгай зөвшөөрлийг сунгаж ажиллах,


Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

1.3.Холбогдох хууль тогтоомж, журам, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хариуцлагын гэрээг байгуулж, хяналт тавьж ажиллах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

1.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг тогтоох тухай тогтоол төслийг боловсруулах,

1.5.Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг тогтоох тухай” 89 дүгээр тогтоолыг хүчингүй болгох,

 / М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр



Гурав.Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгийн  
дарга П.Түвшинжаргал-д:

3.1.Чойбалсан-Чулуунхороот сумын чиглэлийн төмөр замын зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн зорчигчийн суудлын тоог 50 хувийн дүүргэлттэй явуулахыг,

Дөрөв:Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа-д:

4.1.Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, хориглох тухай Улсын онцгой комисс, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан даалгавар, шийдвэрийг хэрэгжүүлэх, тодорхой тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл танилцуулах,

Тав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал,  
Онцгой комиссын гишүүн Должин,  
Сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

5.1.Дайчлан ажилласан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их, дээд сургуулийн оюутны дотуур байр, тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийж хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах,

Зургаа.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ж.Алимаа-д:

6.1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед иргэдийн амжиргааг дээшлүүлэх зорилгоор сүү, цагаан идээ, хүнсний ногоо, жимс жимсгэнийг гадаа талбайд худалдан борлуулахыг зөвшөөрөх,


6.2.Сургалтын үед коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гарах холбогдох зардлуудыг бүрэн гаргуулахыг,

Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой  
комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-т:

7.2.“Степ голд” ХХК, “Мөрөөдлийн ордон” тоглоомын төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу хариу хүргүүлэх,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр-д:

7.3.Хот хоорондын тээврийн хэрэгслийг Улаанбаатар-Чойбалсан чиглэлд 30 зорчигчтой, Чойбалсан-Улаанбаатар чиглэлд 40 зорчигчтойгоор тус тус хөдөлгөөнд оролцуулахыг зөвшөөрөв,

/  / М.Бадамсүрэн  
/ х/ч Б.Цогтбаяр

Биеийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж-д:

- 7.4. Спортын уралдаан, тэмцээнийг ажлын өдрүүдэд зохион байгуулах,
- 7.5. Хариуцлагын гэрээг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газартай байгуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН